

УДК 821.512.36  
DOI 10.18101/978-5-9793-1755-7-355-366

**МОНГОЛ УТГА ЗОХИОЛ ДАХЬ СЭТГЭЛ ЗҮЙН НЭГЭН  
ӨГҮҮЛЭМЖИЙН УЛАМЖЛАЛ ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД**

© Ууганбаатар Ж.

Монгол Улс, Шинжлэх ухааны академи,  
Хэл зохиолын хүрээлэнгийн ЭШАА  
uuganbaatarj@mas.ac.mn

Өрнө дорнын хийгээд нийт утга зохиол тэр дундаа хүүрнэл зохиолын туурвил зүйн түүхэнд олон жилийн уламжлалтай аймшгийн уран зохиол хөгжлийнхөө зүй тогтлын дагуу улс үндэстэн бүрийн уран зохиолд тодорхой түвшинд хөгжиж ирсэн байна. Монголын орчин үеийн уран зохиолд нийгэм цаг үеийн байдлаас үүдэн хэсэг хугацаанд зогсонги байдалтай байсан ч 1990-ээд оноос шинэ агуулгаар баяжиж, уран зохиолын бүхий л төрөл зүйлд нэвтрэн хөгжиж байна.

Энэ төрөл зүйл хөгжин боловсроход гурван хүчин зүйл нөлөөлжээ. Үүнд: Ардын аман зохиолын баримтлаг шинжийг хадгалсан хууч яриа, түүхэн ба домогт агуулга бүхий хүүрнэл зохиолууд, эртний бичгийн уран зохиолын өв, там бирдийн агуулга бүхий туужууд хөгжлийн нэгэн сурвалж болжээ.

Монголын утга зохиолын төрөл зүйлийн баяжилтад сэтгэлзүйн өнгө аясыг илэрхийлсэн /аймшгийн уран зохиол/ өгүүлэмж бүхий зохиол бий болсон явдал нь туурвилзүйн шинэ төлөвшил мөн билээ.

**Түлхүүр үгс:** Монголын утга зохиол, уламжлал, шинэчлэл, аймшгийн уран зохиол

**ON TRADITIONS AND REFORM OF PSYCHOLOGICAL MOTIVES  
IN MONGOLIAN LITERATURE**

J. Uuganbaatar  
Uuganbaatar Jambaa  
Researcher  
Institute of Language and Literature  
Mongolian Academy of Sciences (MAS)  
Ulaanbaatar-51, Mongolia  
uuganbaatarj@mas.ac.mn

The social change atmosphere in Mongolia during the 1990s affected all social and psycho-logical spheres and condemned the tendency of literary studies to value literature in terms of so-cial, political, and ideological roles and had given the chance to study literature in terms of artis-tic and aesthetic dimensions. In the literature of every nation, there are several novels that are purely fictional, often adventurous, and based on psychological fears. In Mongolian literature, writings with psychological motives (horror novels) have developed into some types of oral and written literature. Horror literature, which has a long tradition in the history of Western and East-ern literature in general, and fiction, has developed to a certain extent in the literature of each nation in accordance with the laws of development. Mongolian contemporary literature had been stagnant for some time due to social and contemporary circumstances, but since the 1990s it has been enriched with new content and developed into all genres of literature. The following fac-tors contributed to the development of the genre. Those are: 1) old tales, historical and mytho-logical narratives that retain documentary feature of folklore; 2) ancient literary heritage, and novels with the content about hell and jinn have become a source for the literary development. The emergence of a novel with a psychological state (horror fiction) that enriches the diversity of Mongolian literature is a new development in literature.

Keywords: Mongolian literature, traditions, reforms, horror literature.

Монголд 1990-ээд оноос өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийн уур амьсгал нийгэм, оюун санааны бүхий л хүрээнд нөлөөлжээ. Монголын утга зохиол судлалд уран зохиолыг нийгэм, улс төр, үзэл суртлын үүргийн талаас нь онцгойлон үнэлж ирсэн хандлагыг буруушаан нийгэм, уран сайхан, гоо зүйн хүрээнд судлах бололцоог олгосон.

Улс үндэстэн бүрийн уран зохиолд цэвэр зохиомол үйл явдалтай, голдуу адал сонин явдлыг ихэд шүтэн зохиосон, мөн тохиолдсон юм уу тохиолдож болох гэмээр элдэв хачин зүйлийн тухай өгүүлэхдээ сэтгэл зүйн айдсын талд нь ихээхэн дулдуйдаж бүтээсэн хэсэг зохиол гарч ирдэг байна. Ийм зохиол туурвилыг аймшгийн зохиол гэж нэрлэдэг. Аймшгийн зохиол дэлхийн уран зохиолд нийтлэг хөгжиж иржээ. Хөгжлийн явцад биеэ даасан төрөл зүйлийн хувьд олон үндэстний уран зохиолд хэвшин тогтсон юм. Утга зохиолын онолын бүтээлүүдэд аймшгийн зохиолыг тодорхойлохдоо агуулгын талыг буюу тухайн бүтээлийн бусдад нөлөөлөх сэтгэл зүйн шинжид тулгуурлан үнэлэлт дүгнэлт өгсөөр ирсэн. Английн уран зохиол судлалын гоо зүйн чиглэлд “айдас аймшгийн уран зохиол (horror story) гэдэг сэтгэл зүйн хувьд маш хүнд, хүлээж авахад бэрх, дарамт цочролд оруулах агуулгыг илэрхийлсэн уран зохиолын зүйл” [Paul Procter 1995, 685] гэж томъёолжээ.

Америкийн утга зохиол судлалд “айдас аймшгийн юм уу эсвэл жигшил зэвүүцлийн маш хүчтэй цочролт мэдрэмжийг төрүүлдэг зохиолыг айдас аймшгийн зохиол гэнэ. Өөрөөр хэлбэл, энэ нь сонин хачин хүмүүсийн сэдсэн аймшигтай муухай, хачин санаа бодол, үйл хэргийн тухай өгүүлэмжит зохиол гээд “жишээ нь: хүмүүс аймшиг гэдгийг ойлгож мэдрэхдээ ямар нэгэн зүйлийг үл таньсан мэдрэмж гэж ойлгодог [prof. Hornby, 1995]. Эндээс үзэхэд онолын ерөнхий ойлголтын хувьд илэрхий зөрүү байхгүй хэдий ч нэгэн өвөрмөц ойлголт гарч ирж байгаа нь уг төрлийн зохиол өвөрмөц хачин явдлын тухай бус нийгмийн буюу хүний сайн сайхан амьдрах аж төрөхөд хүчин мөхсөдөж байгаа ойлголтын тухай асуудал бас хамаарах нь тод харагдаж байна. Тодруулбал, хүний оршихуйн бүх талын асуудлыг цочроон доргиосон аюулт хүчний тухай өгүүлсэн агуулгыг ихэвчлэн илэрхийлсэн байдаг. Айдас бол хүний танин мэдэх түвшний ойлголт бөгөөд тухайн зүйлийг хэрхэн ойлгон хүлээн авч байгаа сэтгэлзүйн үзэгдэл ажээ. Аймшгийн зохиол агуулгын хувьд үлэмж өргөн багтаамжтай.

Айдсын хүчин зүйлийг гоо зүйн ойлголттой холбож үзвэл Оросын зохиолч Н.Г.Чернышевский “Байгальд байх гайхамшигтайн зүйлээс бидэнд төрөгдөх сэтгэгдэл бол айдас хүрэх, хүндэтгэн бишрэх хоер болно. Хүсэл шуналын гайхамшиг нь нэг талаас айдас төрүүлэн нөгөө талаас омог бардам хүслийг төрүүлдэг” [Чернышевский Н.Г. 1980,165]. Үүнийг, аливаа хүний танин мэдэх хүсэл нь урьдаас огт төсөөлөлгүй зүйл байдаг ба энэ нь зарим талаар аймшигтай байдлыг бий болгож болох бөгөөд түүнийхээ тухай тодорхой төсөөлөл мэдээлэлтэй болсны дараа тэрхүү аймшигт зүйл нь омог бардам, баатарлаг хүслээр солигддог явцаар тайлбарлаж болох юм. Энгийн үгээр дээрх тодорхойлолтыг ахуйн хүрээнд оруулан тайлбарлавал: Хэн нэгэн хүн хүч тэнцвэргүй араатантай гэнэт тулжээ. Хүчит араатны сүрт хүчин түүнд аймшигт байдлыг төрүүлнэ. Гэтэл тулааны эцсийн бүлэгт амьд үлдэх хүсэл, амьдралын төлөөх тэмцэл уг айдсыг гэтлэн давж ингэснээр ялалтад хүрчээ. Энэ нь омог бардам хүсэл бахархлыг төрүүлжээ хэмээн тодорхойлжээ.

Доктор Д.Галбаатар “Хүн төрөлх мэдрэмжээ алдахын хэрээр түүний хүн чанар нь хомсоддог. Энэхүү айх эмээх, алдагдаж асан мэдрэмжийг нөхөн төлжүүлэх, мөн зориг хүчний хүмүүжил, айх эмээх сэтгэл нэгэн биед зэрэгцэж, өөр өөрийн тунгаар орших нь хүн, хүн хэвээр оршихын үндэс билээ. Монгол хүний ертөнцийг үзэх үзэл түүнтэй холбоотойгоор энэхүү аймшгийн тухай өгүүлж болно” [Галбаатар Д. 1997.131] хэмээн айх эмээх нь хүний оршин байхуйн нэгэн шинж болохыг тодорхойлсон. Тэгэхээр зөвхөн этгээд гажиг сонин зүйлс ч аймшиг биш, харин оршихуйн тухай цогц асуудлыг хамардаг.

Монголын уран зохиолд сэтгэлзүйн өгүүлэмж бүхий /аймшгийн зохиол/ зохиол хөгжихдөө аман ба бичгийн зохиолын зарим төрөлд уламжлагдсан юм.

Академич Ц.Дамдинсүрэн энэхүү төрөлд хамаарах нэгэн өгүүлэмж болох буг чөтгөртэй таарсан, учирсан хүмүүсийн элдэв хууч яриаг цуглуулж хэрэглэгдэхүүн бэлтгэсэн нь өнөөдөр энэ төрөл зүйлийг судлагчдын судалгааны үнэт хэрэглэгдэхүүн болсоор байна.

Академич Х.Сампилдэндэв “Аймшгийн зохиол нь жирийн нэг чамирхал бус хүүхэд залууст айн эмээх мэдрэмж бий болгох зориулалттай. Айх эмээх мэдрэмжгүй бол адал балмад явдал үйлдэж болох юм” [Сампилдэндэв Х, Гаадамба Ш, УБ, 2006] гэжээ. Энэ дүгнэлт уг төрлийн зохиолын бусдад үзүүлэх нөлөө, гоо зүйн хүмүүжлийн үүргийн талаас нь үнэлэн дүгнэсэн хэрэг юм.

Орчин үеийн кино, театрын урлагт хүчтэй дэлгэрсэн аймшигт явдал, аллага, хүчирхийлэл, ер бусын хүчний хөнөөл сүйтгэл, харь гарагийн амьтдын довтолгоо, хорлол, ертөнц дэлхийн сүйрлийн тухай зэрэг өгүүлэмжтэй бүтээлүүдийг нийтэд нь аймшгийн зохиол, кино зэргээр нэрлэдэг. Орчин үеийн өрнө дахин ба Америкийн уран зохиолд аймшгийн зохиол нь бие даасан том төрөл зүйл болжээ. Дорно дахин тэр дундаа монгол аман ба бичгийн уран зохиолд аймшгийн зохиолын төрөл эртнээс хөгжжээ. Үүнд гол төлөв чөтгөр шулмын хорлол, зүүд, зөн билгийн биелэл, хий үзэгдлүүд, амьтдын хувилал, хойд урд насны явдал зэрэг шашны үзлийн өгүүлэмж голлодог [Галбаатар Д. 2002.13].

Монголын утга зохиолд аймшгийн зохиолын үндсэн шинж, туурвил зүйн хөгжлийг нягтлан үзэх хэрэгтэй. Тухайлбал: Академич Х.Сампилдэндэв “Монгол ардын аман зохиол” хэмээх бүтээлдээ “Туурилаг домгийн дотор буг чөтгөр, сүнсний тухай өгүүлсэн нь дэлхий дахинаа өргөн тархсан аймшгийн зохиолын нэг өвөрмөц хэлбэр болж байна. Энэ нь уран сэтгэмжийн нэг хэлбэр болохын зэрэгцээ адгууснаас ялгарах хүний ичих, эмээх, айх мэдрэхүйн дотроос айх мэдрэхүйг төлөвшүүлэх уран сайхны хэрэглүүр буюу хүмүүжлийн асар их нөлөөтэй ажгуу. Энэ нь эр зоригийн хүмүүжилд сөрөг нөлөөтэй бус бөгөөд адгуусны гэмээр балмад авир занг номхотгох учир холбогдолтой” [Гаадамба.Ш, Сампилдэндэв.Х, УБ, 2006.154] гээд “Чөтгөр шулам хий үзэгдлийн тухай хууч яриаг зарим талаар өрнө зүгийн аймшгийн зохиолтой адилтгаж болно. Өрнө зүгийн аймшгийн зохиолд чөтгөр шуламсын дүр олонтоо гардаг бөгөөд монгол түмэн дэлхийн бусад улс үндэстний нэг адил аймшгийн зохиолын өвөрмөц хэлбэрийн бүтээсэн нь чөтгөр шулам, хий үзэгдлийн тухай хууч яриа домог бий” [Сампилдэндэв Х, Гаадамба Ш, УБ, 2006. 282] гэжээ. Тэгвэл сэтгэлзүйн өгүүлэмж бүхий зохиолын дүрийн тухайд доктор С.Байгалсайхан “Монгол утга зохиолд дүрслэгдсэн буг чөтгөр шуламсын дүр нь шууд хүнд их гай гарз хор хүргэдэггүй, харин уулзсан үзсэн харсан сонссон зүйлээсээ болж сэтгэл санааны доройтолд орж нас барсан бие нь муудсан тохиолдол их байна. Тиймээс ч буг шуламс нь утга зохиолд муу талын баатрын илэрхийлэл болон дүрслэгддэг байна. Учрыг нь олоогүй зүйлээ, мэдэж таниагүй юмаа чөтгөр шуламс хэмээн тохоон нэрлэн хэрэглэж заншсан байна.” [Байгалсайхан С. “Аман зохиол судлал” УБ.1999] гэж үзсэн бол, мөн доктор С.Дулам “Монгол домгийн эсрэг талын уран сэтгэмжийн төгөлдөр нэгэн гол баатар чөтгөр (буриад Архан шүдхэр, алтай Эрлэг) бол угтаа ертөнцийг үүсгэн бүтээгчдийн нэгэн бөгөөд сансар ертөнцийн үүслийн домогт өгүүлж байгаагаар бол газар дэлхийг бүтээлцсэн боловч өөрт хувь оноогдоогүйн улмаас гомдож муудалцсан” хэмээн домогзүйн дүрийн талаас [Дулам С. УБ.1989, 139] тодорхойлжээ.

Зохиолын зөрчлийн талаас айдаст хүйдэст зохиол нь хүний жирийн амьдралын хэв шинжийг тусгадаг бус харин хүн ба байгаль, амьтан тэдгээрийн хоорондын зөрчил, үл тайлагдах нууцгай үзэгдэл, хүний сэтгэлийн хэлбэр болох айдас хүйдсийг тусган гаргадаг.

Доктор С.Хөвсгөл “Монгол аймшгийн яриануудын уран сайхны онцлогийн талаар” өгүүлэлдээ “Аман ба бичгийн зохиолын төрөл зүйлүүд нь дүр дүрслэл, хэл, зохиомж

зэргээрээ өөр хоорондоо ялгаатай тус тусын онцлог шинжтэй байдаг билээ. Монгол аймшгийн хууч ярианууд нь нэгэн төрлийн богино зохиол болохын хувьд өөрийн гэсэн онцлог уран дүр, дүрслэл, уран сайхны яруу хэрэглүүрүүдтэй бөгөөд эдгээр нь тухайн ярианы хамгийн гол онцлог болох айдсыг төрүүлж, тодруулахад чухал үүрэгтэй байдаг” [Хөвсгөл.С УБ. 2000] гээд “дүрийн талаас авч үзвэл эдгээр ярианы гол дүрүүд нь чөтгөр шуламс хий үзэгдэл бөгөөд тэдгээр нь янз бүрийн дүрд хувилан харагдаж гэнэт бий болж, гэнэт алга болдог, ер бусын хүч тэнхээтэй, гарт үл баригдах зэрэг онцлог шинжтэй. Тэрчлэн хувилах чадлын хувьд эмэгтэй хүн байснаа цагаан тэмээ эсвэл сүүжний яс, эзэн хятад байснаа, цагаан үнэг болох зэргээр хувирдаг. Энэ нь монгол ардын төдийгүй дорно дахины шидэт үлгэрийн хувирлуудтай төстэй юм” [Хөвсгөл.С УБ.2000] гэж тодорхойлжээ.

Харин дүрийн хувьд ил ба далд хоер хэлбэрээр илрэх ба утга агуулгын талаас нь үзвэл энэ төрлийн зохиол нь угаасаа хүний сэтгэл зүйн байдалтай гүнзгий холбогддог, сэтгэл зүйд хандсан сэтгэлийн дэнслэлийг эрчимтэй илэрхийлэхийг зорьдог. Хүн айх тусмаа тэмүүлэмтгий болдог нь далд ухамсрын сэргэлтийн байдалтай холбоотой. Хэрвээ эмгэнэлт зохиолын гол шинж нь шийдэгдээгүй зөрчилд оршдог бол айдас аймшгийн зохиол нь сэтгэл зүйн тэнцвэрийг “унагах” зорилготой учраас зохиолд дэвшүүлсэн зөрчил гол бус харин адал явдал, айдаст өгүүлэмж уран сэтгэмжүүд гол үүрэгтэй. Энэ шинжээрээ эмгэнэлт зохиолоос ялгардаг байна.

Мөн уран зөгнөлт зохиолоос мөн бие даасан шинжээрээ ялгардаг. Энэхүү байдлыг үзвэл; Зөгнөлт зохиолын хувьд голчлон аливаа үйл, хэрэг явдлыг санаанаасаа юм уу тодорхой мэдээллээс ургуулан зохиодог бол энэ нь байж болох зүйлийн тухай ихэвчлэн өгүүлдэг бол, айдсын буюу аймшгийн зохиол нь хүний оршихуйг хөндөн өгүүлдэг. Хүн айх, ичих, гуних, баярлах, инээх, бодох ... гэх зэрэг хүний сэтгэл зүйн уугуул мөн чанаруудын хувирал, шилжилтүүдийг илүү анхаарч бичдэгээрээ ялгардаг. Аймшгийн төрлийн зохиол нь монголын уран зохиолд дараах хэлбэрээр илэрч байна. Үүнд:

1. Монгол ардын аман зохиолын тодорхой төрөл зүйлийн хүрээнд. Жишээ нь баатарлаг туулийн дүр болон зарим нэг үйл хэрэг явдал өгүүлэмжийн бүтвэр хэсгүүдэд,
2. Бүхэлдээ аймшгийн агуулга бүхий буюу энэ төрөл зүйлийн үндсэн шинжийг бүрэн хадгалсан монгол ардын үлгэр, хууч яриа, аман домог зэргийг дурдаж болно.
3. Монголын эртний уран зохиол болон түүнд холбогдох зарим тууж, яруу найргийн бүтээлд
4. Монголын орчин үеийн уран зохиолын яруу найргийн дууль хэлбэрийн бүтээлд, үргэлжилсэн үгийн богино болон дунд хэмжээний бүтээлд, дэлгэцийн бүтээлд амжилттай хөгжиж, дэлхийн утга зохиолын өнгө аястай сэтгэлгээ туурвилын жишиг түвшин рүү ойртож байгааг харуулж байна.

Ардын аман зохиол хүн ардын ахуй амьдралын уран сайхны тусгал төдийгүй ард түмний ирээдүй, түүнд тэмүүлэх хүсэл мөрөөдөл, зөн бэлгэдлийн яруу сайхны илэрхийлэл байдаг. Энэхүү өв сангийн дотор мангас, буг чөтгөр, шуламс, сүнс сүлд, онго, ер билгийн тухай амаас ам дамжин яригдаж иржээ.

Монгол ардын үлгэр домог, хууч яриа, баатарлагийн туульд аймшгийн зохиолын хэв шинж бүхий хэсэг, дүрслэлийн элемент цөөнгүй байгаагаас үзэхэд энэ төрлийн зохиол нь нийгэм түүхийн хөгжлийн эрт үед үүссэн бололтой. Орчин цагийн бичгийн уран зохиолд аймшгийн зохиол хөгжих үндсэн уламжлал болжээ. Ийм учраас түүний уламжлалыг аман зохиолоос эрж хайх нь зүйн хэрэг юм.

Монгол ардын аман зохиолд элдэв сонин содон явдал бүхий шидэт үлгэрүүдийн дотор сүнс сүлд, ер билиг, мангас, буг чөтгөр, шулам, махчдын тухай өгүүлсэн нь дэлхий дахинаа өргөн тархсан аймшгийн зохиолын сонгодог хэлбэрийн нэг юм.

Дэлхийн улс үндэстний аман зохиолд өргөн дэлгэрсэн үлгэрт мангас, буг чөтгөр, шулам, махчны дүрийн дотроос зэрлэг адгуусан амьтны шинж чанартай, махчин хүний

дүр монгол ардын үлгэрийн өгүүлэмжид айдас аймшгийн өнгө аясыг бий болгосон гэж үзэж болмоор байна. Энэ нь өвөрмөц хэв шинжит дүр юм.

Уран зохиолд энэ өвөрмөц дүр хүн иддэг махчин болсон “хүний” буюу “мангасын” дүрийн уламжлал бөгөөд “мангас нь монгол туульд хөгшдийг хөнөөж, хүн ардыг барьж, эхнэр хүүхдийг нь булааж, эр чадалтайг нь алж байхаар дүрслэгдсэн байдаг. Эндээс үзэхэд мангасын дүр нь эхийн эрхт есны үед анх бүрэлдэн бий болж эцгийн эрхт есны үед бүрэн төгөлдөр хэлбэрийг олсон байна” [Катуу Б. Уб 2004.251] гэж үздэг нь хожим бичгийн уран зохиолд чөтгөр, шуламсын дүрээр эрлэг, там бирдийн орны өгүүлэмжит зохиолоор уламжлан, орчин үеийн уран зохиолд аман хууч яриа болон хүүрнэл зохиолд үзэсгэлэн гоо бүсгүйн дүрээр муу үйлийг сэдэгч, эсвэл ямар нэгэн буг сүнсний дүрээр илэрч байна.

Мөн ийм төрлийн аман зохиолоос бичгийн уран зохиолд уламжлахдаа эрлэг тамын орны айдсын агуулга бүхий бүтээлүүдэд уламжлан иржээ. Тухайлбал: Молон тойны су-дар, Чойжид дагинын тууж зэргээр уламжлагджээ.

Монгол ардын аман зохиолд буг чөтгөр, сүнс сүлд, онгоны тухай домог, хууч яриа тогтсон сэдэв, агуулгатай, туурвил зүйн хувьд бие даасан шинжтэй өвөрмөц туурвил юм.

Туурилаг хууч яриа нь адал явдал, уран сэтгэмж давамгайлсан бодит амьдралтай таарахгүй гаж мэт боловч тухайн өгүүлэгч үнэхээр болсон явдал, өөрөө үзсэн мэтээр ярьдаг онцлогтой. Ийм хууч ярианд алмас, сүнс, чөтгөр, хий үзэгдлийн тухай голлон өгүүлдэг. Тэрхүү өгүүлэмжид гэрч байдаггүй зөвхөн өгүүлэгч өөрт юм уу бусдад тохиолдсон явдлыг хүүрнэдэг.

Туурилаг хууч яриа нь орчин үеийн явдлыг тэр тусмаа өнөөгийн бидний үед “болсон” явдлыг уран сэтгэмжээр баяжуулан өгүүлэх нь цөөнгүй. Тухайлбал: “Цэнхэр цувтнуудтай харьцдаг үл мэдэгдэх хачин хүмүүс” хэмээх хууч ярианд од гаригийг дурандан судалдаг эмэгтэй харь гаригийнхныг санамсаргүй олж харснаас эрхшээлд нь орж “Цэнхэр цувтан” дүрээр ирсэн тэдний үүрэг даалгаврыг биелүүлж эх дэлхийн тухай мэдээлэл цуглуулж өгөх болсноор сэтгэл мэдрэлийн өвчтөний тухай мэдээлэл олохын тулд сэтгэцийн гажигтай хүний дүрээр эмнэлэгт хүртэл хэвтэж мэдээллээ олоод цэнхэр цувтнуудад дамжуулахаар эмнэлгээс оргож байгаа тухай өгүүлдэг.

Чөтгөр, шуламс, хий үзэгдлийг харах нь тухайн хүний сэтгэцийн онцлогтой холбоотой байж болох зүйл. Хойт төрлөө олоогүй үхсэн хүний сүнс чөтгөр болсон тухай өгүүлэмж олон байдаг. “Талийгаачийн шарил дээр муур шээснээс чөтгөр болсон нь” гэдэг хууч ярианд “муур эзнээ үхээсэй гэж шөнө бүр гурав тойрдог, харин нохой эзнээ үхчихвий гэж мөн л шөнө бүр гурав тойрдог” гэсэн яриа байдаг тухай өгүүлээд нэгэн айл талийгаачийн шарилыг банаг буюу илүү гэртээ оруулж гурав хонуулахдаа хаяа хатавчийг нь сайн хамхиагүйгээс болж тэжээвэр муур нь орж талийгаачийн толгой руу шээчхээд нүүрийг нь долоосноос болж сүнс нь чөтгөр болж, гэрэлтсэн нов ногоон нүдтэй нүүр биеэрээ дүүрэн үс бүрхсэн адгуус хүн хоерын аль нь үл мэдэгдэх амьтны дүрд хувилан оршуулсан газрынх нь дэргэдүүр явсан машины жолоочид харагдаж айлгасан тухай өгүүлнэ. Буг чөтгөрийн, дүрийн тухайд зайран Чагнаагийн ярьснаар бол хөх хөтлийн чөтгөр нь зэвхий цагаан царайтай, гөлийсөн нүдтэй хүүхэн байжээ. Энэ мэт “Ачаатай үхэр”, “Хөх торгон дээлтэй залуу хүүхэн”, “Хувин барьсан хүүхэн” гэх мэт янз бүрийн дүрээр явуулын хүнд харагдаж айлгасан тухай өгүүлэх аж. Үүний учир шалтгааныг талийгаачийг хөдөөлүүлэх үеийн явдал, цээртэй зүйл, эдлэл хэрэглэл, хувцас өмсгөлтэй холбоотой гэж тайлжээ. Чөтгөр хийгээд хий үзэгдэл өдөр харагдахгүй, харин харанхуйд үзэгдэхээр барахгүй элдэв дуу чимээ гаргадаг гэж хууч ярианд голдуу дүрслэн өгүүлэх агаад дүрс нь харагдавч барих биегүй гэж гарах боловч зарим хууч ярианд биетэй бодитой сүнс буюу чөтгөртэй нөхөцсөн тухай өгүүлж байна.

Чөтгөр, шулам, хий үзэгдлийн тухай хууч яриаг зарим талаар өрнийн аймшгийн зохиолтой жишин ойлгож болно. Өрнө зүгийн аймшгийн зохиолд чөтгөр шуламсын дүр

олонтоо гардаг бөгөөд монгол түмэн дэлхийн бусад улс үндэстний нэг адил өөрийн үндэстний аж төрөл, сэтгэлгээг хадгалсан аймшгийн зохиолын өвөрмөц хэлбэрийг бүтээсэн нь чөтгөр, шуламс, хий үзэгдлийн тухай хууч яриа домгууд юм. Аймшгийн зохиол нь жирийн нэг айлгах зорилготой бус хүүхэд залуусын айн эмээх мэдрэмжийг сэргээх зориулалттай. Айх эмээх мэдрэмжгүй бол адал балмад явдал үйлдэж болох талтайг хууччуул аймшгийн зохиолоор засан тэнцвэржүүлж өгдөг байжээ.

Аман ба бичгийн зохиолын алив төрөл зүйлүүд нь дүр, дүрслэл хэл, зохиомж зэргээрээ ялгаатай, тус тусын онцлог шинжтэй байдаг. Тиймээс ч бидний өмнө өгүүлсэн аймшгийн өгүүлэмж бүхий хууч ярианууд нь богино зохиолын шинжтэйн хувьд уран дүр, дүрслэлтэй, уран сайхны олон зүйл яруу хэрэглүүрийг ашиглаж чөтгөр, шулам, хий үзэгдлүүд: янз бүрийн хэлбэр дүрсэд хувилан харагддаг, гэнэт үзэгдэж, гэнэт алга болдог, ер бусын хорлох, хөнөөх, айлгах чадалтай, гарт үл баригдах зэрэг өвөрмөц онцлогтой ажээ.

Буг чөтгөр, сүнсний тухай аймшгийн хууч яриануудыг элдэв, агуулга, үзэл санаа, уран сайхны талаасаа аман ба бичгийн зохиолын хосолмол шинжийг хадгалсан, биеэ даасан төрөл зүйл юм. Сэдэв, өгүүлэмж, уран дүр, дүрслэлтэй бөгөөд тухайлбал, нэг хэсэг яриа нь хөдөө хээр, аян замд тохиолддог чөтгөр, хий үзэгдлийн тухай сэдэвтэй байхад өөр нэг хэсэг нь нас барсныхаа дараа гэр орон, үр хүүхэд, эд хогшилдоо хоргодсон сүнсний сэдэвтэй байдаг. Түүнчлэн чөтгөр шулмыг янз бүрийн дүрд хувилах чадалтай, гэнэт гарч ирж, гэнэт алга болдог, хүч чадлаараа хүнээс илүү гэх мэтээр дүрсэлж, чөтгөртэй тааралддаг орон зай, цаг хугацааг болзолт байдлаар үзүүлсэн байдаг зэрэг нь хууч ярианы уран сайхны гол онцлог юм.

Баатарлагийн тууль нь өргөн дэлгэр агуулга, төгөлдөр дүр дүрслэл, тансаг хэл найруулгатай. Монгол туульд олны бахархал, хүч чадлын бэлгэдэл баатар эр, ажнай хурдан хүлэг, хүний хэлийг мэддэг эрдэм увдист сайн морь, төгөлдөр их эрдэмтний сэтгэлийг ч хөдөлгөх, төгс их баатрын зоригийг ч уяраах үзэсгэлэнтэй хатад дагинас, амьд бүхний эрлэг болсон аюулт мангас зэрэг эерэг сөрөг дүрүүд гардаг. Үлгэр, туульд амар жаргалыг бусниулахаар довтлон ирж буй мангасын байдлыг “хар утаа манарч, харанхуй манан үзэгдэж, цасан бороо орж, чулуун мөндөр бууж, гэрэлт нарны гэгээ тасарч, гай зовлон болох” зэргээр байгалийн үзэгдэл ба гай гамшигтай холбон дүрсэлж байжээ. Тэгэхээр газар хөдлөх, аянга цахилгаан цахих, салхи дэгдэх, галт уул дэлбэрэх, гал түймэр үер усны аюул тохиох, арслан заан, үлэг гүрвэлээс эхлээд аварга могойг хүртэл аймшигт амьтан, араатан жигүүртнээс айх гайхах, алмайрах, сүрдэх, сандрах, мэгдэж бишрэх, сүслэх, хүчгүйдэх, мөхсөдөх зэргээс болж нүдээр үзэж биеэр туулснаа ой ухаандаа бясалгаж үр хүүхэд, хойч үедээ өвлүүлж уламжлуулахдаа уг мэддэгийг хамгийн товч тодорхой ойлгомжтой, тэхдээ айдас төрж, аймшигт явдалд учрах түгшүүрийг мангас гэгч дүр агуулжээ. Мангас нь нэгд хүмүүсийн гашуун туршлагын сургамж, хоерт айдас хүйдсийн үр дүн, гуравд сүсэг бишрэлийн далд ухамсар, дөрөвд болзошгүй аюулаас сэргэмжлэх дохиолол, тавд ес суртахууны ердийн хэв хэмжээний үр дүн юм. Сүүлдэж ирээд нийгмийн хөгжлийн явцад ангийн ялгаа бий болж хүмүүс байгалийн гай гамшгийн хор хөнөөлийг амсахаас гадна анги нийгмийн дарлал мөлжлөгийг бие сэтгэлээрээ амсах болов. Тиймээс мангас гэгч нь байгаль нийгмийн гамшгийг биедээ шингээсэн, хүн төрөлхтний сэтгэлгээний нэгэн цаг үед гарч ирсэн хатуу харгис хэрцгий дүрийн нэг болж төлөвшсөн байна.

Судлаач Б.Катуу “Мангас нь монгол туульд хөгшдийг нь хөнөөж, хүн ардыг барьж, эхнэр хүүхдийг нь булааж, эр чадалтайг нь алж байхаар заяагдсанаар дүрслэгдсэн байдаг. Эндээс үзэхэд мангасын дүр нь эхийн эрхт есны үед анх бүрэлдэн бий болж эцгийн эрхт есны үед бүрэн төгөлдөр хэлбэрийг олсон байна гэж үзэж болно” [Катуу Б. 2004. 262] гэж дүгнэжээ.

Баатарлаг тууль сонсогчийн сэтгэл зүй эерэг эсрэг байрлал руу үргэлж шилжиж мангасын дүрслэл, хэрэг явдлыг өгүүлэхэд “айдас аймшиг”-т автан байх ахул туулийн эерэг

баатрын хэрэг явдал өгүүлэгдэхэд “бахархал, баяр хөөр” бялхаж байдаг онцлогтой. Иймд баатарлаг тууль дахь “мангас” баатар болон түүний “шулам” хатан, унаа хөсөг, орон гэр, амьдралын орчны дүрслэл сүр хүч хийгээд хөнөөл сүйтгэл зэрэг нь эртний айдсын (аймшгийн) зохиолын нэг үндсэн төрөл, дүр болжээ.

Монголын эртний иргэний болон шашины агуулгатай бичгийн уран зохиолд буг чөтгөр, бирд болон хүмүүн бус муу төрөлтөн, тэдний оршигч эрлэг тамын орны тухай өгүүлсэн зохиол бүтээл цөөнгүй бий. Эдгээр зохиол нь орчин үеийн айдас аймшгийн зохиол хөгжин бий болох үндсэн язгуур сурвалж болохын хувьд дараах хоёр хэлбэрээр уламжлан иржээ. Нэгдүгээрт, Бурхан шашны уран зохиол дахь магтаал шүлэг, тухайлбал: Турфаны цуглуулгын доторх “Там бирдийн тухай” магтаал шүлэг. Хоёрдугаарт, Бурхан шашны уран зохиол дахь тууж “Чойжид дагины тууж”, “Молон тойны намтар”, “Гэсэр эхийгээ тамаас авсан нь”, “Эндүүрэл хааны тууж” зэрэг туужаар уламжлагдсан гэж болно.

Монголын эртний бичгийн уран зохиолын салшгүй хэсэг бол бурхан шашны уран зохиол юм. “Монгол орон дахь бурханы шашны дунд үеийн дэлгэрэлт буюу Их Юань улсын Өлзийт, Хайсан хүлэг, Буянт хааны төрд бурханы шашны номыг Монгол хэлээр урьж байх үеэс бурхадын магтаал шүлгийг яруу сайхан туурвих болсон биетэй баримт нь Тэнгэр уул, Эрээн хавиргын цаадахь Турфан нутгаас олдсон бичгийн дурсгалаас мэдэгдэж байгаа яруу найргийн зонхилох төрөл ХИҮ зууны үеэс уламжлан ирсэн магтаал, сургаалын шүлэг зүй есоор орно” [Цэрэнсодном Д. УБ, 1997, 319 тал]. Ийнхүү Монголчууд ХИҮ зууны эхэн үед Бурханы шашны уран зохиолын яруу найргийн магтаал шүлгийг өөрийн хэлнээ туурвиж байсан бөгөөд, тодруулбал Турфаны цуглуулгын дурсгалаар уламжилжээ. “Билиг барамид”-ын магтаал, “Там бирдийн тухай” магтаал шүлэг тэргүүтнийг нэрлэж болно.

Бурханы шашны сургаал есоор энэ яваа насанд нүгэл хилэнц үйлдэж буян ном эс хийвээс хойт төрөлдөө гурван муу заяаны /там, бирд, адгуус/ тамд унана хэмээн номлодог. Ийм учраас энэхүү эрлэг тамын орны дүр төрхийг жирийн хүмүүст ухааруулах түүнээс цээрлэж, айж эмээлгэхийн үүднээс ийм сэдэвтэй шүлэг, дуулал, домог тууж тэргүүтэн өдий төдий олон зохиол гарсан.

Монголчуудын эртний уламжлалт баатарлаг туульд ч хүртэл энэхүү эрлэг тамын орны байдал дүрслэгдсэн байхаас үзвэл энэ сэдэв монгол уран зохиолд нэлээд эрт орж ирсний гэрч гэж хэлж болно. Тухайлбал: Монгол Гэсэрийн туужийн олон хувилбаруудад Гэсэр Богд хаан эхийнхээ сүнсийг эрлэг тамын орноос гарган авч, дээд тэнгэрт төрүүлсэн тухай бүлэг бий.

Турфаны цуглуулын 35 мөр шүлэгт тамын тухай

“Хэдүйхэн бэр буяныг үл хийх

Хэлэх нүглийг үйлдэгчин

Хэрвээ тамаас тоншбоос

Хэсгээр бирд дор төрjöү хэмээгээд

Айльт төдий хээлтэй

Уульт төдий тэргүүт

Асар нарийн хоолойт

Алхан ядах хөлтөн буй“

гэх зэргээр аймшигт бирд хэмээх зовлонт амьтны төрхийг уран яруу шүлэглэсэн байдаг нь хожуу үеийн там, бирдийн сэдэвт туужид мөн уламжлан үлдсэн нь бий. Тухайлбал:

“Алхан ядах хөлтэй

Айлын төдий тэргүүтэй

Уулын төдий биетэй

Асар хялгасны чинээ толгойтой”

гэж “Молон тойны сударт” шүлэглэжээ. “Молон тойны сударт” өгүүлснээр Бирд дор төрх гол шалтгаан алт, мөнгө эд, идээн үлэмж бөгөөтөл харамлан хайрласны тул болой гэсэн байна.

Ганжуурын доторх “Дамбанэршаг” хэмээх зохиолд бирдийн 36 зүйлийг өгүүлсэн байх авч XIV зууны эхэн үеийн энэхүү бирдийн шүлэгт өглөг бүхнээс хагацсаны харгайгаар атаа харамд автагдсаны өлсөгч бирдийн дүр төрхийг голон өгүүлсэн байна. Ийм учраас Монгол ардын зүйр цэцэн үгэнд “Бирдийн нүдэнд далай ширгэнэ” гэдэгтэй тун ойролцоогоор:

“Нарийн хөлтөн бирдийн нүдэнд

Нуур далайн усан бэр ширгэж

Намрын сараар халуун болмой” гэх зэргээр бирдийн сэтгэл хэзээд үл ханах байнгын өлсгөлөн, юм идье гэвч хялгасан хоолойг үл давна. Давлаа гэхэд идсэн идээ нь үл шингэх төдийгүй халуун ширэм болж түлэн тарчилгана хэмээн өгүүлсэн байдаг. Энэхүү бирдийн оронд 700 төрөлдөө зүдэж явж үүнээс тонилбол адгуусны төрлийг олж мөн 700 төрөлдөө мунхаг адгуус болж нэгэн нэгнээ барьж идэх, мах арьсны төлөө тамлуулах, зодож балбуулах эдлүүлж талхиулах, өлсөж, ундаасах тэргүүтэн элдэв зовлонг эдэлж хүний төрлийг олох хувь тохиолоо гэхэд идээ ундаар үргэлж дутуу дурган гуйланч ядуу хүмүүс болно хэмээн номлосон байдаг. Энэ бүх сургаалын цаана хадгалагдаж буй гол санаа нь олдохуйяа бэрх эрдэнэт хүмүүний биеийг олсон энэ завшаанаа буян ном үйлдэхгүй төрхгүй, жудаггүй явж өнгөрөөвөл яаж ч харамсаад нэмэргүй. Түмэн үеийн гаслан болно хэмээн аймшигт зураглал өгүүлэмжээр дүрслэн үзүүлжээ.

Эрлэг тамын орны дүр төрхийг нарийн үзүүлсэн зохиол ХҮШ зуунаас XIX зууны үед монгол хэлээр нэлээд дэлгэрчээ. Ийм зохиолын ихэнх хэсгийг төвдөөс орчуулсан боловч зарим нэг Монгол ахуй, Монгол аж амьдралд ойртуулсан олон зохиол байна. Жишээ нь: “Гэсэр хаан эхийгээ тамаас гаргасан”, “Молон тойны судар”, “Чойжид дагинын тууж”, “Тамын зурагт ном” зэрэг зохиол юм.

Эдгээр эрлэг тамын орны сэдэвт зохиолын дотроос бандида Цэвэлванчигдоржийн “Тамын зурагт ном” ном нь нүглээс үүдэх үйлийн үрийн шалтгаан үр дагаврыг зурагтай хавсарган үзүүлсэн нь там бирд буг чөтгөрийн тухай хүнд илүү хүрч айж эмээх, жигшин зэвүүцэх сэтгэлийг төрүүлсэн зохиол Монголын орчин үеийн уран зохиолд туурвилд аймшгийн агуулга бүхий энэ төрөл зүйлд хамаарах бүтээл цөөнгүй байна. Үүний нэгэн илрэл бол монгол дууль юм. Дууль бол хурц зөрчил, бадрангуй эмгэнэлийн агуулгатайгаараа онцгой төрөл бөгөөд дуулийн зүйлүүд дотроос домог дууль нь олны анхаарал татсан, ардын аман домог хууч ярианд суурилсан, уран сэтгэмжийн шинжтэй буюу, хурц зөрчилд үндэслэсэн гүн эмгэнэлт шийдэлтэйгээрээ эрс ялгарч байна.

Ид шид, ер билэг, илбэ, буг чөтгөр, сүнс сүлдний тухай сэдэвт зохиол бүтээл нь дэлхийн урлаг, уран зохиолд байдаг ба энэхүү сэдэвт зохиолыг триллер буюу айдаст аймшгийн адал явдалт зохиол гэж нэрлэж байна.

Айдаст хүйдэст зохиол нь хүний жирийн амьдралын хэв шинжийг тусгадаг бус харин хүн ба байгаль, амьтан тэдгээрийн хоорондын зөрчил, үл тайлагдах нууцгай үзэгдэл, хүний сэтгэлийн хэлбэр болох айдас хүйдсийг тусган өгүүлдэг билээ. Аливаа шинэ юм бүрэлдэн гарч ирэхдээ шууд цоо шинээр үүсэн бий болдоггүй өнгөрснийхөө дэвшилтэд тал дээр тулгуурлан дараагийн шинэ зүйл гарч ирдгийн адил энэхүү триллер зохиол уран зохиолын шинэ төрөл зүйлүүдтэй харьцуулбал нэлээд эртний уламжлалтай ба айдас аймшгийн өгүүлэмж бүхий хууч яриа, тууль, домог зэрэгт тусгагдсан байдаг төдийгүй Энэтхэг, Япон, Хятад, Солонгос зэрэг дорно дахины улс түмний аман зохиолд ч уламжлан ирсэн байдаг билээ.

Хэдийгээр монголын шинэ уран зохиолд айдас аймшгийн хэсэг өгүүлэмж бүхий олон зохиол байгаа ч чухам аймшгийн зохиолын шинжийг бүрэн илтгэж чадах богино хэлбэрийн хүүрнэлүүд нь 1990 хэдэн оны үеийн уран зохиолд хамаарна. Энэхүү дүгнэл-

тийн баталгаа болгон академич Х.Сампилдэндэвийн тодорхойлсноор ишилбэл: “1990 оноос хойших уран зохиол, нийгмийн үзэл санааны эрс эргэлтийг янз бүрээр тусгаж, сөрөх, дасан зохицох хоер хэлбэрээр хариу илэрхийлэл үзүүлж байна. Үүнд:

а. Нийгмийн амьдралын шинэ хэвшлийг сөрөх чиглэл нь нэгдүгээрт; гутрал, гуниг, мухардал, ирээдүйд үл итгэх байдал, өнгөрснийг санагалзах, үгүйлэн харамсах үзэл санааг илэрхийлсэн декадент чиглэл, хоердугаарт; яруу найргийн салбарт хүчтэй илэрч буй нийгмийн шинэ тогтолцооны сул тал, шилжилтийн үеийн бэрхшээл зовлонг хурцаар илэрхийлж шүүмжлэн буруушаах үзэл санааг түлхүү гаргасан нийгмийн шүүмжлэлт чиглэл.

б. Нийгмийн амьдралын шинэ хэвшилд дасан зохицох чиглэл нь нэгдүгээрт; нийгмийн оюун санааны задралын үеийн сэтгэл зүйг ашиглаж уран зохиолын олз ашиг бий болгогч хэрэгсэл болгон ашиглахыг зорьж буй прагматик чиглэл, хоердугаарт; өнөө үеийн сэтгэлгээ оюун санааны хоосон орон зайг ашиглаж өрнийн утга зохиолын урсгал чиглэлүүдийг хэл бэрд эх байдлаар дуурайж бичдэг туурвилзүйн ядуухан төвшинд урлан туурвиж буй формалист чиглэл эдгээр бөгөөд хамгийн гол нь туурвилзүйн хувьд чанарын шинэчлэл гараагүй байна. Гэвч олзуурхууштай нэг зүйл бол социализмын үед хөрөнгөтний гэдэг нэрийн дор ил аргаар бичихийг хориглодог байсан формалист буюу хийсвэрлэх урлагийн чиглэл, орчин үеийн модернист уран бүтээлийн аргаар бичих бололцоо нээгдэж энэ чиглэлээр залуу уран бүтээлчид авьяас чадвараа сорьж буй явдал юм” [Сампилдэндэв Х. 2006.17] гэснийг дурдаж болно. Учир нь энэ үеийн айдас аймшгийн зохиол нь дээрх дүгнэлтийн “Нийгмийн амьдралын шинэ хэвшилд дасан зохицох чиглэл” гэсэн хэсэгт хамаарах бөгөөд нийгмийн өөрчлөл, үзэл бодлын чөлөөт байдал, монголын шинэ уран зохиолын сэдвийн либеральчлалын үр дүн гэж болохоор байгаа юм.

Ийнхүү дээрх ойлголтод тулгуурлан үзвэл 1990 хэдэн онд айдас аймшгийн бие даасан гэж болохуйц хэд хэдэн өгүүлэл гарсны нэг нь дорно дахиныг судлагч эрдэмтэн зохиолч Я.Ганбаатарын “Сүнсний дуудлага” өгүүлэлгийн түүвэр юм. Зохиолд шашны уран зохиолын нэг гол жанр болох зүүд зөн, сүнс сүлд, урд хойд нас, үйлийн үрийн шалтгаан, буг чөтгөрийн амилал, хорлол сүйтгэлийн тухай аймшгийн зохиолын хуучин уламжлалыг шинэ үеийн уран зохиолд нэлээд сонирхолтой хэлбэрээр сэргээн урласан нь нэгэн шинэ үзэгдэл болсон гэж болно. Я.Ганбаатарын зохиол нь бичлэгийн хувьд өрнө дахины сэтгэлгээний уран чадвар аргатай ойр байхад хэлбэр нь дорнын шинжийг илүү хадгалсан байгаа нь зохиолчийн эрлийн чиг дэлхийн утга зохиол түүхэн хөнжлийн хандлага, үндэсний түүхэн уламжлал тэгш зохируулах эрмэлзэлтэй холбоотой төдийгүй түүний уран бүтээл бүхэлдээ монголын утга зохиолын уламжлалт реалист бус аргатай гүн гүнзгий холбогдож байгааг хэлэхгүй байхын аргагүй. Тэрээр Дорно дахины судлаачийн хувьд тэдгээр орны аман ба бичгийн зохиолыг уншин судлах явцдаа тэдгээр орны эртний сонгодог уран зохиолын өв сан, ид шид, сүнс сүлд, зүүдний хэлбэр өгүүлэмжтэй зохиолоор арвин болохыг мэдэж бас цөөнгүй зохиолыг орчуулан хэвлүүлсэн нь түүний бүтээлд багагүй нөлөөлжээ. Я.Ганбаатарын өгүүлэлгийн дүрийн систем онцлогтой, сонирхолтой юм. Зохиолын дүр нь ямар нэгэн сүнс ба түүний нөлөөлөл болсон дүрслэхүүнтэй холбогдсоноор зохиолын зөрчил бий болж ямар нэгэн эмгэнэлт явдалд хүргэх нь түүний зохиолыг аймшигт айдастай болгодог төдийгүй үйл явдлын өрнөлийг эрчимжүүлж санаанд оромгүй шийдэл рүү хөтөлдгөөрөө уншигчдыг гойд татдаг юм. Мөн өгүүлэгдэхүүний түргэн өөрчлөлт нэг нь нөгөөгөөсөө урган гарах нарийн дараалал бүхий явдлууд нь зохиолыг нэн үнэмшилтэй амьд болгож байна. Мөн дутагдалтай тал нь өдгөө цагийн хүн бүрд итгэл үнэмшил төрүүлэхээргүй гэнэтийн “үсрэлт” үйл явдалд гарч [Галбаатар Д. УБ. 2006.183] байна.

“Аалз” өгүүлэлт нэгэн залуу угаалгын өрөөндөө орвол халуун усны онгоцон дотор эрхийн чинээ хар аалз байж байна. Зэвүүцэн эгдүүцэндээ халуун ус тавьж хоолойгоор нь урсгаад усанд орно. Хоер хоногийн дараа ахиад л нэг аалз байх ба түүнийг мөн л дээрх байдлаар урсган ална. Энэ явдлын дараа залуугийн цээжин дээр нэгэн эрхийн хурууны

чинээ толбо үүсэж байна. Удалгүй залуу өвдөн, аалзны шүлсэнд өлгөгдчихөөд салж ядан байгаагаар зүүдлэн тарчилсаар байгаад нас барж байна. Оршуулах ажил болоод өнгөрсний дараа эхнэр мөн угаалгын өрөөндөө орж усанд орох гэтэл бас нэгэн аалз байх бөгөөд урсгах гэтэл нөгөө аалз амь гуйн нэрээр нь дуудах шиг болно. Ингээд нөгөө аалзаа гараа тосон автал бие нь эвгүйцэн бас нэгэн толбо гар дээр нь гарах бөгөөд удалгүй бас нас барж байна. Сүсэг, ер зүүд зөн, хорлох сэтгэл төрөл арилжих, орон солих зэрэг ардын аман зохиолын сонирхолтой аргуудыг сэтгэл зүйтэй холбосон төдийгүй энэрэхүй есыг өргөмжилсөн агуулгатай, үйл явдлын өрнөл ба шийдэлт нь аймшгийн зохиолын хэв маягтай болгожээ[Галбаатар Д. УБ. 2006.186].

Тэгвэл “Шинэхэн хууч” өгүүллэгт оюутны байрны нэгэн өрөө. Таазнаас дүүжигнэн байх аалзтай жаргаж эхэлнэ. Удалгүй оюутан төгсөж, ут өрөөнд шинээр сургуульд элссэн оюутан орж амьдарна. Нэгэн удаа хар дарж зүүдэлснийгээ нөгөө аалзнаас боллоо хэмээн аалзыг шатаана. Энэ бүсгүй хүний дуу хадаж их гал манасхийн, бөөн галд автана. Тэр цагаас хойш өнөөх өрөөнд хэн ч суухгүй бөгөөд шөнө дөлөөр бүсгүй хүний гаслант дуу сонсогддог болжээ. Энэ өгүүллэгт “энэрэхүй сэтгэлийн агуу их хүч, хорлолт муу сэтгэлийн үр дагаврын харьцааны асуудлыг хөнджээ. Энэрэнгүй зөөлөн сэтгэл буг чөтгөр, сүнс сүлдийг ч номхруулж чаддаг, ойворгон муу араншин хорлолт сэтгэл хунийг өөрийг нь ч сүүгэдэг жам есыг” энэ зохиолоороо харуулсан байна.

Энэ бүхнээс үүдээд дүгнэхэд зохиолч Я.Ганбаатар орчин үеийн Америк болон өрнө дахины айдас, аймшигт аллага, хүчирхийллийн эрээ цээргүй хатуу хээ маягийг бус үндэсний уламжлалт аман болон бичгийн уран зохиолд нэн баялаг өв сантай сүнс сүлд, ад чөтгөрийн сэдэвтэй аймшгийн зохиолын бараглан маргагдсан түүхэн уламжлалын суурин дээр дөрөөлөн эрэл хийж орчин цагийн “шидэт зохиолын шинэ хэлбэршил бий болгоход багагүй анхаарч байгаараа онцлог гэж болно. Тэрээр бага залуудаа өтгөс настны хэлдэг үлгэр домгийн гайхамшигт автан сүнс, буг чөтгөрийн элдэв явдлыг сонсон айн уйлж суухдаа хожим хойно амьдрал гэдэг их далайд хөвж явахад тохиолдох элдэв бэрхшээлийг даван туулах сэтгэлийн их хат олж авч байснаа одоо л ухаарч байна. Ер нь аймшгийн зохиол гэдэг хүнийг зөвхөн айлгаж тарчилгадаг харгис хортой зүйл бус харин хүнийг амьдралын хэцүү бэрхийг туулахад бэлтгэдэг урлагийн өвөрмөц арга байжээ. Одоогийн хүмүүст айж ичих сэтгэлийг эргүүлж өгөхөд ийм чиглэлийн ном зохиол хүүхэд залуус их хэрэгтэй гэж өгүүлсэн байдаг. [Я.Ганбаатар “Сүнсний дуудлага” ном, УБ, 1997] “Сүнсний хорлолт”, “Хөсөр хэвтсэн хөх аргалын домог”, “Номын хүч, билгийн мэлмий”, “Савдаг”, Гүйдэлтэй газар” зэрэг хориод өгүүллэг цөм хуучны домгоос эх үүсгэлтэй ч, өгүүлэмж нь орчин цагийн хэрэг явдлыг сонирхолтой хэлбэрээр өгүүлж уран зохиолын уламжлал, залгамжлал, шинэчлэлийн нэгэн жишээ болохын зэрэгцээ уран чадварын хувьд ч чамбай бүтээл болсон юм.

Тэгвэл ачлал элбэрлийн агуулгыг сүнс сүлд, хойт насны тухай өгүүлэхдээ аймшгийн зохиолын хэв маягтайгаар өгүүлсэн өөр нэгэн өгүүллэг бол Д.Энхболдын “Аалз”, “Жоом”, Ж.Сарантуяагийн “Дэлт цагаан азарга” зэрэг өгүүллэг юм.

Сүүлийн жилүүдэд зохиолч Ц.Ууганбаярын “Хөргөгч”, “Сүүлчийн хүч”, “Зоорь”, “Шуургатай шөнө”, “Хорсол”, “Алиалагч”, “Хар цэцэг”, “Мессэж”, “Цогцос чангаагч”, “Цахилгаан шат” зэрэг сэтгэл зүйн айдаст өгүүллэгүүд гарсан нь энэ төрлийн зохиолын өгүүлэмж, агуулгын хувьд шинэ туршиц болжээ.

Нийгмийн амьдралын шинэ хэвшилд дасан зохицох чиглэлийн буюу задралын үеийн сэтгэл зүйг ажиглаж өнөө үеийн сэтгэлгээ, оюун санааны хоосон орон зайг ашиглаж, өрнийн уран зохиол, урлагийн урсгал чиглэлийн олон бүтээл гарсан нь урлаг утга зохиол дахь зүй есны үзэгдэл мөн.

Тайз дэлгэцийн бүтээлд төрөл зүйлийн хөгжлийн явцад тодорхой бүтээлүүдэд айдас, аймшгийн тухай дүрслэл багагүй шигтгэгдсэн.

Монгол киноны зүтгэлтэн, зураач Соелын гавьяат зүтгэлтэн П.Цогзолын 1979 онд бүтээсэн “Бушхүүгийн үлгэр” кино зохиол олны сонирхлыг ихэд татсан юм. Ардын аман зохиолын өгүүлэмжид тулгуурласан үнэнч шударга явдал нь аз жаргалд хөтлөн хүргэдэг тухай ардын үзэл санааг үлгэрийн хэлбэрээр илэрхийлэхдээ аймшигт дүр байдал бүхий шуламсын дүрийг дэлгэцнээ анхлан урлажээ. Бүтээлд сүүжний ясаар хад цохиход сэрдэг, хүн болж хувирдаг, дийлдэшгүй хүчтэй, атгаг муу санаатай, араг яс биетэй, тал бие нь хар, аалзан духтай бүхэлдээ хар хорын бэлгэдэл болсон айдсын шинж бүхий шулмыг дүрсэлжээ. Айдсын шинжийг тусгасан зохиол бол Төрийн шагналт зохиолч Д.Мягмарын “Нандин эрдэнэ” жүжгийн, кино зохиолын хувилбар нь юм. Зохиолд хүнд өвчтэй эхээ энэрэн асрахаасаа илүүтэй эхийнхээ зүүсэн алтан бөгж ээмгэнд нь шунан тачааж хөрж амжаагүй бүлээхэн цогцоос салган авч буй буртагт сэтгэлтэнг үзүүлсэн юм. Нийгмийн айдсын асуудлыг хурцаар хөндсөн энэ бүтээл үзэгч олны талархлыг ихээхэн хүлээжээ. Талархал хүлээхийн хирээр нийгмийн аймшгийг агуулсан ийм хүн бидний дунд байгааг сануулан хэлсээр байсан юм. Аймшгийн шинж бүхий уран зохиолын зүйлс нь хөгжлийн нэгэн үе дүрийг тодчилсон байдалтайгаар эсвэл туслах шинжтэйгээр дүрслэгдэж өгүүлэгдэж байсан 1990 хэдэн оны эхэн үеэс үзэгч уншигч судлаачдын анхаарлыг татсан “Алт амилах цаг” /1992/ болон “Орчин үе” театрынхны найруулан хийсэн “Ядуугийн зовлон”, “Диваажингаас амьдрал хүрэх замд”(1999), “Улаан ой” (2004), “Хана” (2007), “Дэв” (2010), “Дуудлага”, “Хөлтрөг”, “Зоорь” (2013), “Хүүхэлдэй” (2015) зэрэг кино дэлгэцийн бүтээлийг дурдаж болно.

Төрийн шагналт зохиолч Д.Төрбатын “Алт амилах цаг” бүтээлд цаг бусаар насан эцэслэсэн нэгэн эмэгтэйн сүнс нь өөрийн үнэт эдэндээ хоргодсон тухай өгүүлж байна. Энэрэхүйн учир холбогдол бүхий агуулгыг айдсын шинжээрээ дамжуулан илэрхийлжээ.

“Орчин үе” театрын бүтээсэн “Ядуугийн зовлон” кино туужид монгол нутагт аж төрж, хураасан хөрөнгөө эдэлж амжилгүй нас нөгчсөн хятадын нуусан алтыг амьдралд хөл тэнцэн яваа залуу олжээ. Гэвч түүний олсон алт эмгэнэлт хувь тавилангийн эхлэл болж олон хүний амийг авч одсоор байна. Зохиолоор хүний шунал, тачаал, атаа хорлолыг жирийн нэгэн нийгмийн сэхээтний аж амьдралаар төлөөлүүлэн хүний оршихуй сэтгэхүйн айдсыг хөнджээ.

Сүүлийн жилүүдэд урлаг уран зохиолын олон төрөл зүйл, хөгжлийнхөө зүй тогтлоор төлөвшин, баяжиж байгаагийн нэг илэрхийлэл энэхүү айдас, аймшгийн төрлийн зохиолын шинжийг агуулсан анхны триллер кино гарсан явдал юм. Залуу найруулагч Л.Бат-Амагалангийн “Улаан ой” кино бөгөөд монголын дэлгэцийн урлагт шинэ үзэгдэл болжээ. Тодруулбал, энэхүү кино урьд тогтсон хэвшмэл загварчлалыг зөрчсөн, чөлөөт өгүүлэмжтэй, дүрийн холбоо, үйл явдлын зангилаа шийдэл нь залуусын аяллын түүхээр дамжин, 1930 хэдэн онд уулнаа лам нарыг хомроглон устгасан гашуун түүхийг шинэ /залуус/ хуучин үе /лам нар/-ээр холбож /одоо ба өнгөрсөн үе/, тэрхүү аймшигт түүхийн улбаа өнөө цагт оршноор залуус үйл явдлын төгсгөлд амьдралын төлөө тэмцэж бие биеэ таньж байна. Зохиолын гол санаа нь нийгмийн хүчирхийлэл, дарангуйлал нь эргээд ирээдүйд нийгмийн шинэ аймшиг төрүүлж байгааг “Улаан ой” киноны өгүүлэмжээр илэрхийлжээ.

2010 оноос монголын аймшгийн кино сэдэв, өгүүлэмжийн хувьд “Дэв”, “Дуудлага” зэрэг сэтгэхүйн аймшгийн кино, “Хөлтрөг”, “Зоорь”, “Хүүхэлдэй” зэрэг триллер чиглэлийн кинонууд гарсан юм. Сүүлийн үеийн киноны өгүүлэмж айдас хүргэм аймшгийн дүрслэлийг шингээхээс илүү агуулгын талаас үзэгчид рүү улам ойртсон, аймшгийн зураглал, урлах хийц, ур маяг улам бодитой болж, тайлал зохиомжийн хувьд нарийн болсоор байна.

Өрнө дорнын хийгээд нийт утга зохиол тэр дундаа хүүрнэл зохиолын туурвил зүйн түүхэнд олон жилийн уламжлалтай аймшгийн уран зохиол хөгжлийнхөө зүй тогтлын дагуу улс үндэстэн бүрийн уран зохиолд тодорхой түвшинд хөгжиж ирсэн байна. Монго-

лын орчин үеийн уран зохиолд нийгэм цаг үеийн байдлаас үүдэн хэсэг хугацаанд зогсонги байдалтай байсан ч 1990-ээд оноос шинэ агуулгаар баяжиж, уран зохиолын бүхий л төрөл зүйлд нэвтрэн хөгжиж байна.

Энэ төрөл зүйл хөгжин боловсроход гурван хүчин зүйл нөлөөлжээ. Үүнд: Ардын аман зохиолын баримтлаг шинжийг хадгалсан хууч яриа, түүхэн ба домогт агуулга бүхий хүүрнэл зохиолууд, эртний бичгийн уран зохиолын өв, там бирдийн агуулга бүхий туужууд хөгжлийн нэгэн сурвалж болжээ.

Монголын утга зохиолын төрөл зүйлийн баяжилтад сэтгэлзүйн өнгө аясыг илэрхийлсэн /аймшгийн уран зохиол/ өгүүлэмж бүхий зохиол бий болсон явдал нь туурвилзүйн шинэ төлөвшил мөн билээ.

### Ном зүй

1. Арьяасүрэн Ч. эмхэтгэсэн “Намайг тойрсон сүнс чөтгөрийн тухай яриа” УБ., 1991.
2. Аман зохиол судлал ХХШ боть УБ 2001
3. Байгалсайхан С. Утга зохиол дахь буг, чөтгөр, шулмасын дүрийн тухай // Аман зохиол судлал. УБ., 1999.
4. Гаадамба Ш, Сампилдэндэв Х. Монгол ардын аман зохиол. УБ, 1988.
5. Ганбаатар Я. Сүнсний дуудлага: ном УБ., 1997.
6. Галбаатар Д. Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь. Токио. 2002.
7. Галбаатар Д. Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд. УБ., 2001.
8. Галбаатар Д. Урлахуйн галыг бадраагч зул эндүүрлийн гэмийг ариусгагч зул. УБ., 2006.
9. Даваасүрэн Б. эмхэтгэсэн. Буг, чөтгөртэй таарсан хүмүүсийн бодит явдлууд. цуврал. УБ., 2003.
10. Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм. II дэвтэр, 1977.
11. Дамдинсүрэн Ц. Монгол уран зохиолын дээж зуун билэг. УБ., 1959.
12. Дулам С. Монгол домог зүйн дүр. УБ., 1989.
13. Жамьяан Г. Сүнстэй нөгчсөн хүн. УБ., 1995.
14. Катуу Б. Монгол туулийн дүрийн тогтолцоо. УБ., 2004.
15. Катуу Б. Нэгэн туулийн нэрийн учир // Аман зохиол судлал. ХҮШ боть. УБ., 1987.
16. Катуу Б. Монгол туульсын бэлгэдэл. УБ., 1996 (1997).
17. Procter P. Cambridge international dictionary of English. New York: Cambridge university press, 1995.
18. Ринчен Б. Манай ардын туульс // Монгол ардын баатарлаг туульсын учир. УБ., 1966.
19. Сампилдэндэв Х, Гаадамба Ш. Монгол аман зохиол. УБ., 2006.
20. Сампилдэндэв Х. Монгол хууч ярианы дээж. УБ., 2003.
21. Сампилдэндэв Х. Монголын шинэ үеийн уран зохиолын туурвил зүйн зарим асуудал. УБ., 2006.
22. Түдэв Л. Сүнс сүлд // “Дал” сонины хавсралт. УБ., 1999.
23. Уран зохиол судлал. ШУА. ХЗХ. ЭШБ. УБ., 1997.
24. Ууганбаяр Ц. Шулмын инээд. УБ., 2006.
25. Хөвсгөл С. Монгол аймшгийн яриануудын уран сайхны онцлогийн талаар. УБ., 2000.
26. Хэл зохиол хүрээлэн, АЗНАС-ийн фонд № 15. 517 х.
27. Цэрэнсодном Д. Монголын уран зохиол. УБ., 1987.
28. Цэрэнсодном Д. Монголын бурханы шашны уран зохиол. УБ., 1997.
29. Цэрэнсодном Д. Монгол домог туулийн гарал үүслийн асуудалд // Аман зохиол судлал. ХҮУ боть. УБ., 1987 (1984).
30. Чернышевский Н. Г. Урлаг үнэн байдалтай гоо зүйн талаар харьцах учир нь. УБ., 1980.
31. Qusby Ian. Cambridge international dictionary of English. New York: Cambridge University press, 1995.